



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХҮН АМ, ӨРХИЙН ТАНИЛЦУУЛГА 2018



Улаанбаатар хот
2019 он

**ХЯНАСАН:**

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

М.Батхишиг

ЧД-ын Статистикийн хэлтийн ахлах
мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот
Утас: 70113013
70130767
70110767
976-11-310767

Цахим хуудас: www.ubstat.mnwww.chingeltei.gov.mnИ-мэйл: chingeltei@nso.mn




ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нийт хүн ам 2018 онд 157258 болж, өмнөх оноос 1793 (1.1%) хүнээр буурчээ. Дүүргийн хэмжээнд 2018 онд 3630 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 134 (3.6%) хүүхдээр буурсан байна.

Хүснэгт 1. Монгол Улс, Нийслэл хотын хүн амын тоо, дүүргээр, оноор

Засаг захиргаа	2014	2015	2016	2017	2018
Монгол Улсын нийт хүн ам	2 995 949	3 057 778	3 119 935	3 131 750	3 186 347
Нийслэлийн дүн	1 314 486	1 345 500	1 380 792	1 417 396	1 444 669
Чингэлтэй	159 514	154 819	158 014	159 051	157 258
Багануур	28 333	28 419	28 973	28 787	29 512
Багахангай	3 903	4 131	4 143	4 100	4 399
Баянгол	208 898	205 663	214 278	221 384	226 869
Баянзүрх	308 672	320 852	327 123	336 932	343 619
Налайх	34 547	35 813	36 425	36 911	37 608
Сонгиохайрхан	295 827	307 224	315 802	322 458	321 150
Сүхбаатар	136 424	137 633	136 569	138 726	145 335
Хан-Уул	138 368	150 946	159 465	169 726	178 919

Чингэлтэй дүүрэгт Нийслэл хотын хүн амын 10.9 хувь, Монгол Улсын хүн амын 4.9 хувь нь байнга оршин сууж байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 8.9 мянган га бөгөөд нэг километр квадрат талбайд 1761 хүн ногдож байна.



Төрөх үеийн хүйсийн харьцаа 107.2 байгаа нь шинэ төрсөн 100 охин хүүхэд тутамд 107 эрэгтэй хүүхэд мэндэлж буйг харуулж байна. Харин 2018 оны суурин хүн амын тоогоор хүйсийн харьцаа 94.7 байгаа нь дүүргийн 100 эмэгтэй тутамд 95 эрэгтэй ногдож байна. Уг үзүүлэлтийн улсын дүн 96.6, нийслэлийн дүн 93.4 байна.

Хүн амын дундаж наслалт 2018 онд улсын дундаж 70.2, нийслэлийн дундаж 71.6 байна. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт улсын дундаж 75.8 байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 9.6-р өндөр байна.

Хүснэгт 2. Чингэлтэй дүүргийн хүн амын тоо, хороогоор, оноор

Хороо	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	159 514	154 819	158 014	159 051	157 258
1 -р хороо	3 750	3 872	3 928	3 900	4 232
2 -р хороо	3 354	3 268	3 328	3 431	3 414
3 -р хороо	5 793	5 439	5 605	6 060	6 766
4 -р хороо	5 282	5 030	4 848	5 219	5 118
5 -р хороо	4 918	4 699	5 319	4 911	5 229
6 -р хороо	6 718	7 424	7 393	7 523	7 987
7 -р хороо	13 657	12 827	13 048	13 596	12 834
8 -р хороо	4 994	4 546	4 483	4 535	4 354
9 -р хороо	7 906	7 420	7 569	7 247	7 364
10 -р хороо	8 306	7 905	8 328	8 096	7 946
11 -р хороо	6 185	6 040	5 958	5 776	5 585
12 -р хороо	15 647	14 691	15 073	15 665	15 248
13 -р хороо	8 624	8 137	8 361	8 275	8 203
14 -р хороо	8 202	7 948	8 054	7 580	7 694
15 -р хороо	9 135	8 539	8 583	8 945	9 226
16 -р хороо	12 210	12 614	12 714	12 751	12 202
17 -р хороо	14 043	14 247	13 798	13 860	13 372
18 -р хороо	9 864	9 336	9 721	9 784	9 082
19 -р хороо	10 926	10 837	11 903	11 897	11 402


Суурин хүн ам гэдэг нь тухайн нутаг дэвсгэрт 183 хоног, түүнээс дээш хугацаагаар байнга оршин сууж буй юм. Дүүргийн суурин хүн амын тоо 157258 болж өмнөх оноос 1793 хүнээр буюу 1.1 хувиар буурчээ. Хүн амын тоо өмнөх оноос буурахад төрөлтийн түвшин буурсан мөн шилжин явалт их байгаа нь голлон нөлөөлсөн байна.



Хүн амын төрөлт нас баралт болон албан ёсны шилжилт хөдөлгөөний зөрүүгээр тооцсон хүн амын тоо 156685 байна. 2018 оны суурин хүн амын тоо тооцооллын хүн амаас 573 хүнээр их гарчээ. Энэ нь албан ёсны шилжилт хөдөлгөөнд оролцоогүй боловч дүүргийн нутаг дэвсгэрт 183 хоног, түүнээс дээш хугацаагаар оршин сууж буй хүн 573 хүнээр нэмэгдсэнийг илтгэж байна.


Дүүргийн хороодын хүн амын дундаж 8276 байгаа бол дунджаас их хүн амтай 7 хороо, дунджаас бага хүн амтай 12 хороо байна. Хамгийн их хүн амтай 12 дугаар хороонд 15248 хүн байнга оршин сууж байгаа нь дүүргийн нийт хүн амын 9.7 хувийг эзэлж байна.

Зураг 1. Хороодын хүн амын тоо



Дүүргийн хүн амын тоо 1992 оноос 72402 (85.3%) хүнээр, 2010 оноос 9820 (6.7%) хүнээр тус тус өссөн байна. Зурагнаас харахад жилийн дундаж өсөлтийн хурд аажимаар буурах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд Нийслэлийн хэмжээнд орон сууцны хороолол, хотхон ихээр баригдаж байгаа боловч Чингэлтэй дүүргийн хороодод томоохон орон сууцны хороолол, хотхон баригдахгүй байгаа нь хүн хүн амын өсөлтийн хурд саарахад голлон нөлөөлж байна.

Зураг 2. Хүн амын тоо, жилийн дундаж өсөлт, оноор



Хүснэгт 3. Хороодын хүн амын зарим үзүүлэлт, 2018 он

Хороод	Нийт хүн ам			Хүн ам зүйн ачаалал ¹	0-14 насны хүүхдийн ачаалал	65, түүнээс дээш өндөр настаны ачаалал
		Эрэгтэй	Эмэгтэй			
Дүүргийн дүн	157 258	76 479	80 779	52.5	46.0	6.5
1 -р хороо	4 232	1 881	2 351	63.5	52.0	11.5
2 -р хороо	3 414	1 567	1 847	60.4	49.7	10.7
3 -р хороо	6 766	3 053	3 713	63.4	53.9	9.5
4 -р хороо	5 118	2 332	2 786	50.8	40.8	9.9
5 -р хороо	5 229	2 402	2 827	57.4	45.5	11.9
6 -р хороо	7 987	3 718	4 269	59.2	51.1	8.1
7 -р хороо	12 834	6 303	6 531	51.8	47.3	4.4
8 -р хороо	4 354	2 105	2 249	46.5	39.7	6.8
9 -р хороо	7 364	3 614	3 750	46.8	41.5	5.3
10 -р хороо	7 946	3 933	4 013	48.6	43.8	4.7
11 -р хороо	5 585	2 791	2 794	47.2	41.8	5.4
12 -р хороо	15 248	7 475	7 773	52.2	47.7	4.5
13 -р хороо	8 203	4 009	4 194	51.3	45.9	5.4
14 -р хороо	7 694	3 831	3 863	50.1	44.6	5.5
15 -р хороо	9 226	4 490	4 736	53.4	47.7	5.7
16 -р хороо	12 202	6 122	6 080	49.2	43.7	5.5
17 -р хороо	13 372	6 676	6 696	52.4	46.0	6.4
18 -р хороо	9 082	4 463	4 619	49.9	44.0	5.9
19 -р хороо	11 402	5 714	5 688	54.6	46.4	8.2

¹ 15-64 насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настаны тоо

Дүүргийн нийт хүн амын 76479 буюу 48.6 хувь нь эрэгтэй, 80779 буюу 51.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүн ам зүйн ачаалал 2018 онд 52.5 болж өмнөх оноос 2.9 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн тутамд 46 хүүхэд, 7 хөгшид ногдож байгааг харуулж байна. Уг үзүүлэлтийг хорооны түвшинд авч үзвэл 1 дүгээр хороонд хамгийн өндөр буюу 63.5 хувь, 52 нь хүүхэд, 11.5 нь хөгшид

байна. Дүүргийн 2, 3, 5, 6 хороод нь Нийслэл хотын төв хэсэгт байрладаг бөгөөд хүн ам зүйн ачаалал мөн өндөр үзүүлэлттэй гарсан байна. Чингэлтэй дүүргийн орон сууцны хороодод Нийслэл хотын анхны орон сууцны барилгууд байрладаг ба өндөр настанууд байрандаа тогтвортой амьдардаг нь нөлөөлж байна. Мөн сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муутай үед хотын төвийн сургуульд хүүхэддээ сургах гэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн нөлөөлж байна.




Төрөлт нас баралтын зөрүүгээр хүн амын тоо 2765 хүнээр нэмэгдсэн бол, шилжилт хөдөлгөөний механик өсөлтийн зөрүүгээр хүн амын тоо 5140 хүнээр хасагдсан байна. Ердийн цэвэр өсөлтийн коэффициент 17.5 промилль байгаа нь 1000 хүн ам тутамд 18 хүн шинээр мэндэлсэн байна. Мөн шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент 2018 онд 32.5 промилль байгаа нь 1000 хүн тутмын 33 нь шилжин явсан байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Хүн амын ердийн болон механик өсөлт, өсөлтийн коэффициент, оноор

Он	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент	Шилжин ирсэн	Шилжин явсан	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент
2010	3 594	1 024	2 570	17.9	14 421	10 796	3 625	25.2
2011	3 960	1 071	2 889	19.2	11 803	9 015	2 788	18.6
2012	4 659	1 065	3 594	23.4	8 546	8 206	340	2.2
2013	4 608	841	3 767	24.3	8 757	8 644	113	0.7
2014	4 638	1 006	3 632	23.0	10 050	9 967	83	0.5
2015	4 751	960	3 791	24.1	8 596	9 402	-806	-5.1
2016	4 475	916	3 559	22.8	10 682	11 841	-1 159	-7.4
2017	3 764	960	2 804	17.7	9 082	14 152	-5 070	-32.0
2018	3 630	865	2 765	17.5	8 707	13 847	-5 140	-32.5

Зураг 3-аас харахад 2010 онд дүүргийн 1000 хүн тутамд шилжих хөдөлгөөний зөрүүгээр 25 хүнээр, төрөлт, нас баралтын зөрүүгээр 18 хүнээр нэмэгдэж, хүн амын өсөлтийн хурд эерэг буюу 5.5 хувьтай байсан бол 2015 оноос шилжих хөдөлгөөний зөрүүгээр 1000 хүн тутамд 5 хүнээр буурч, төрөлт нас баралтын дүнд 24 хүнээр нэмэгдэн жилийн дундаж өсөлтийн хурд 2.9 хувиар буурч эхэлсэн байна. 2018 онд уг үзүүлэлт 1000 хүн тутамд шилжих хөдөлгөөний өөрчлөлтөөр 32 хүн явж, төрөлт нас баралтын зөрүүгээр 17 хүн нэмэгдэж, өсөлтийн хурд 1.1 хувиар буурсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан байна.

Зураг 3. Хүн амын жилийн дундаж өсөлт, ердийн болон шилжих хөдөлгөөний коэффициент, оноор




Хүснэгт 5. Дүүргийн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо, нас, хүйсээр, 2018 он

Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	157 258	76 479	80 779	50	1 747	787	960
Нас: 0	3 630	1 878	1 752	51	1 722	802	920
1	3 447	1 818	1 629	52	1 716	775	941
2	3 758	1 938	1 820	53	1 587	716	871
3	3 920	1 965	1 955	54	1 663	769	894
4	4 035	2 077	1 958	50-54 нас	8 435	3 849	4 586
0-4 нас	18 790	9 676	9 114	55	1 551	673	878
5	3 852	1 940	1 912	56	1 546	696	850
6	3 646	1 858	1 788	57	1 335	576	759
7	3 406	1 714	1 692	58	1 416	635	781
8	3 140	1 604	1 536	59	1 267	563	704
9	3 210	1 633	1 577	55-59 нас	7 115	3 143	3 972
5-9 нас	17 254	8 749	8 505	60	1 169	500	669
10	2 951	1 513	1 438	61	1 024	435	589
11	2 612	1 365	1 247	62	964	393	571
12	2 022	1 017	1 005	63	844	353	491
13	1 920	962	958	64	773	327	446
14	1 862	943	919	60-64 нас	4 774	2 008	2 766
10-14 нас	11 367	5 800	5 567	65	621	255	366
15	1 880	993	887	66	574	226	348
16	1 890	967	923	67	438	172	266
17	1 909	937	972	68	574	237	337
18	2 053	1 017	1 036	69	417	152	265
19	2 075	1 057	1 018	65-69 нас	2 624	1 042	1 582
15-19 нас	9 807	4 971	4 836	70	412	164	248
20	1 960	987	973	71	388	147	241
21	2 093	1 020	1 073	72	338	136	202
22	2 028	971	1 057	73	319	116	203
23	2 212	1 111	1 101	74	284	100	184
24	2 227	1 134	1 093	70-74 нас	1 741	663	1 078
20-24 нас	10 520	5 223	5 297	75	256	100	156
25	2 080	1 041	1 039	76	284	115	169
26	2 606	1 301	1 305	77	222	89	133
27	3 056	1 463	1 593	78	262	112	150
28	3 331	1 661	1 670	79	154	59	95
29	3 416	1 672	1 744	75-79 нас	1 178	475	703
25-29 нас	14 489	7 138	7 351	80	180	86	94
30	3 469	1 736	1 733	81	144	50	94
31	3 135	1 586	1 549	82	123	40	83
32	3 082	1 534	1 548	83	114	43	71
33	3 038	1 485	1 553	84	121	42	79
34	2 818	1 407	1 411	80-84 нас	682	261	421
30-34 нас	15 542	7 748	7 794	85	84	15	69
35	2 629	1 302	1 327	86	86	30	56
36	2 550	1 213	1 337	87	62	17	45
37	2 384	1 191	1 193	88	62	19	43
38	2 324	1 116	1 208	89	46	15	31
39	2 290	1 116	1 174	85-89 нас	340	96	244
35-39 нас	12 177	5 938	6 239	90	34	14	20
40	2 309	1 136	1 173	91	24	7	17
41	2 167	1 036	1 131	92	16	5	11
42	2 158	983	1 175	93	16	6	10
43	2 157	1 064	1 093	94	15	4	11
44	2 095	993	1 102	90-94 нас	105	36	69
40-44 нас	10 886	5 212	5 674	95	7	4	3
45	1 987	956	1 031	96	4	0	4
46	1 955	912	1 043	97	6	3	3
47	1 816	873	943	98	3	0	3
48	1 822	854	968	99	3	0	3
49	1 823	846	977	95-99 нас	23	7	16
45-49 нас	9 403	4 441	4 962	100, + нас	6	3	3

Хүн амын нас хүйсийн суварга нь нас хүйсийг ерөнхий бүтцээр нь хуваарилан харахад хамгийн тохиромжтой арга юм. Графикаас харахад 2010 оны хүн амын бүтэц 20-39 насанд өргөссөн нь тухайн үед ажиллах хүчны таатай буюу цонх үе байв, харин 1990-2005 онд төрөлт багасч 5-19 насны хүн амын жин буурч байжээ.

Харин 2018 оны хүн амын бүтцэд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэн нөлөөлж 0-9 насны хүн амын тоо нэмэгдсэн байна. Мөн 25-34 насны хүн ам харьцангуй их байгаа нь хөдөлмөрийн насны залуучууд дийлэнх хэсгийг эзэлж, хөдөлмөр эрхлэлтийн таатай үе үргэлжилж байгааг харуулж байна.

Зураг 3. Хүн амын нас хүйсийн суварга, оноор



Хүснэгт 6. Чингэлтэй дүүргийн суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, оноор

Насны ангилал	2016		2017		2018	
	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй
Нийт дүн	158 014	81 754	159 051	86 122	157 258	80 779
0 нас	3 725	1 807	3 764	3 764	3 630	1 752
1-4	15 903	7 763	14 847	7 335	15 160	7 362
5-9 нас	15 990	7 792	16 554	8 134	17 254	8 505
10-14 нас	9 909	4 841	10 910	5 370	11 367	5 567
15-19 нас	10 205	5 173	10 074	5 050	9 807	4 836
20-24 нас	11 567	5 875	10 938	5 594	10 520	5 297
25-29 нас	17 669	9 081	16 730	8 630	14 489	7 351
30-34 нас	15 333	7 959	15 612	8 081	15 542	7 794
35-39 нас	12 334	6 434	12 856	6 782	12 177	6 239
40-44 нас	10 894	5 721	11 111	5 860	10 886	5 674
45-49 нас	9 429	5 024	9 585	5 102	9 403	4 962
50-54 нас	8 376	4 592	8 378	4 562	8 435	4 586
55-59 нас	6 477	3 591	6 721	3 771	7 115	3 972
60-64 нас	3 991	2 298	4 297	2 489	4 774	2 766
65-69 нас	2 389	1 415	2 631	1 555	2 624	1 582
70, түүнээс дээш нас	3 823	2 388	4 043	4 043	4 075	2 534

Чингэлтэй дүүргийн нийт хүн амын 15565 (9.9%) нь цэцэрлэгийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 11185 (71.9%) нь цэцэрлэгт хамрагдаж байна. Харин нийт хүн амын 30448 (19.3%) нь сургуулийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 26785 (88.0%) хувь нь сургуульд хамрагдаж байна. Тэтгэвэрийн насны хүний тоо 15445 болж өмнөх оны мөн үеэс 703 (4.8%)-аар өссөн байна. Дүүргийн хэмжээнд 2018 онд 46 хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байна.

Хүснэгт 7. Дүүргийн хүн амын тоо, насны ангилалаар, хороогоор, 2018 он

Хороо	Цэцэрлэгийн насны хүүхэд (2-5 нас)		Сургуулийн насны хүүхэд (6-17 нас)		Өндөр настан (эр-60+, эм-55+)	
		эмэгтэй		эмэгтэй		эмэгтэй
Дүүргийн дүн	15 565	7 645	30 448	14 942	15 445	10 854
1 -р хороо	396	194	958	461	590	431
2 -р хороо	313	145	730	341	432	317
3 -р хороо	695	324	1 480	715	828	589
4 -р хороо	446	218	894	467	683	466
5 -р хороо	494	240	961	476	719	502
6 -р хороо	856	433	1 596	785	873	610
7 -р хороо	1 312	660	2 494	1 221	993	720
8 -р хороо	422	217	732	358	477	330
9 -р хороо	708	336	1 306	645	667	471
10 -р хороо	750	365	1 557	772	652	470
11 -р хороо	510	243	1 071	517	552	396
12 -р хороо	1 587	781	3 016	1 512	1 190	858
13 -р хороо	814	397	1 525	751	733	522
14 -р хороо	736	378	1 455	690	709	501
15 -р хороо	959	468	1 750	895	802	557
16 -р хороо	1 232	607	2 306	1 136	1 109	769
17 -р хороо	1 338	675	2 612	1 254	1 312	897
18 -р хороо	894	430	1 722	833	846	610
19 -р хороо	1 103	534	2 283	1 113	1 278	838

Сургуулийн өмнөх боловсрол: 2018-2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн 28, төрийн өмчийн бус 30 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Тус хичээлийн жилд цэцэрлэгт 11185 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд өмнөх оноос 201 (1.7%)-р буурсан дүнтэй байна. Энэ нь сүүлийн жилүүдэд төрөлт буурч байгаатай холбоотой.

Ерөнхий боловсролын сургууль: Дүүргийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн 17, төрийн бус өмчийн 8 сургууль үйл ажиллагаа явуулж байна. 2018-2019 оны хичээлийн жилд нийт 26789 хүүхэд суралцаж байгаа бөгөөд суралцагчдын тоо өмнөх оноос 36 (0.14%) сурагчаар өссөн дүнтэй байна.


Нийт суралцагчдын 13384 (49.9%) эмэгтэй суралцагч байна. 2019 оны хичээлийн жилд 3204 хүүхэд 1 дүгээр ангид элсэн суралцсан байна.

➤ ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД

Нийгмийн зарим үзүүлэлтийн судалгаагаар 2018 онд бүтэн өнчин 161 хүүхэд бүртгэгдсэн нь дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 0.4 хувийг эзэлж байна. Бүтэн өнчин хүүхдийн 95 (59.0%) нь эмэгтэй хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо өмнөх оноос 1 (0.6%) хүүхдээр өссөн байна. Бүтэн өнчин хүүхдийг насны бүлгээр авч үзвэл 7 (4.4%) нь 0-4 настай, 25 (15.5%) нь 5-9 настай, 63 (39.1%) нь 10-14 настай, 20 (12.4%) нь 15 настай, 28 (17.4%) нь 16 настай, 18 (11.2%) нь 17 настай хүүхэд байна.

2018 онд хагас өнчин 1619 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оноос 4 (0.2%) хүүхдээр өссөн байна. Дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 3.5 хувь нь хагас өнчин хүүхэд байна. Хагас өнчин хүүхдийн 827 (51.1%) нь эмэгтэй хүүхэд байна. Хагас өнчин хүүхдийг насны бүлгээр авч үзвэл 205 (12.7%) нь 0-4 настай, 522 (32.2%) нь 5-9 настай, 564 (34.8%) нь 10-14 настай, 126 (7.8%) нь 15 настай, 131 (8.1%) нь 16 настай, 71 (4.4%) нь 17 настай хүүхэд байна.


Зураг 7. Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо, оноор



➤ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ

Өрх толгойлсон хүний тоо 2366 болж өмнөх оны мөн 332 (16.3%) хүнээр өссөн байна. Өрх толгойлсон нийт эцэг, эхийн 1645 (69.5%) нь 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эх байна. 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тоог хүүхдийн тоогоор авч үзвэл 762 (46.3%) нь 1 хүүхэдтэй, 513 (31.2%) нь 2 хүүхэдтэй, 243 (14.8%) нь 3 хүүхэдтэй, 87 (5.3%) нь 4 хүүхэдтэй, 34 (2.1%) нь 5 хүүхэдтэй, 6 (0.3%) нь 6, түүнээс дээш хүүхэдтэй байна. 2008 онд өрх толгойлсон нийт эцэг, эхийн 75 хувь нь өрх толгойлсон эх байсан бол 2018 онд үг үзүүлэлт 87 хувь болж 12 промиллээр өссөн байна.

Зураг 8. Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, 2008, 2018 он



Нийгмийн зарим үзүүлэлтийн 2018 оны судалгаагаар дүүргийн хэмжээнд алдарт эхийн одонтой 6566 эх байгаагийн 1833 (27.9%) нь алдарт эхийн I одонтой эх, 4733 (72.1%) алдарт эхийн II одонтой эх байна.

Алдарт эхийн I одонтой эхийн хүүхдийн нийт тоо 11925 бол 1 эхэд ногдох хүүхдийн дундаж тоо 6.5, алдарт эхийн II одонтой эхийн нийт хүүхдийн тоо 19778 бол нэг эхэд ногдох дундаж тоо 4.2 байна.



Хүснэгт 8. Алдарт эхийн одонтой эхийн тоо, хүүхдээр, хороогоор

Захиргаа	Алдарт эхийн одонтой нийт эх	Нийт хүүхдийн тоо	Алдарт эхийн I одонтой эх	Хүүхдийн тоо	Алдарт эхийн II одонтой эх	Хүүхдийн тоо
Дүүргийн дүн	6 566	31 703	1 833	11 925	4 733	19 778
1-р хороо	132	614	26	171	106	443
2-р хороо	87	416	25	163	62	253
3-р хороо	218	1 062	45	325	173	737
4-р хороо	197	954	48	320	149	634
5-р хороо	186	858	45	287	141	571
6-р хороо	253	1 194	63	410	190	784
7-р хороо	710	3 256	171	1 056	539	2 200
8-р хороо	233	1 098	62	397	171	701
9-р хороо	327	1 593	83	574	244	1 019
10-р хороо	319	1 662	114	796	205	866
11-р хороо	316	1 554	116	737	200	817
12-р хороо	482	2 394	115	735	367	1 659
13-р хороо	408	1 974	108	722	300	1 252
14-р хороо	357	1 750	105	687	252	1 063
15-р хороо	481	2 287	149	914	332	1 373
16-р хороо	666	3 217	158	1 080	508	2 137
17-р хороо	367	1 834	114	773	253	1 061
18-р хороо	268	1 195	62	386	206	809
19-р хороо	559	2 791	224	1 392	335	1 399

➤ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 4101 болж өмнөх оны мөн үеэс 505 (11.0%) хүнээр буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 1869 (45.6%) нь эмэгтэйчүүд, 528 (12.5%) нь 0-17 насны хүүхэд, 80 (2.0%) нь 65 түүнээс дээш насны хүн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаанаар авч үзвэл 1662 буюу 40.6 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, 2162 буюу 52.7 хувь нь өвчнөөр, 213 буюу 5.2 хувь нь осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.


Дүүргийн 0-17 насны хүүхдийн 528 (1.0%) нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өвчний төрлөөр авч үзвэл 39 (7.4%) нь харах эрхтний өөрчлөлттэй, 29 (5.5%) нь сонсголын бэрхшээлтэй, 17 (3.2%) нь ярианы бэрхшээлтэй, 79 (15.0%) нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 68 (12.9%) нь сэтгэцийн эмгэгтэй, 109 (20.6%) нь хавсарсан согогтой, 187 (35.4%) нь бусад өвчний төрөлд хамрагдаж байна.

Дүүргийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролд хөгжлийн бэрхшээлтэй 155 хүүхэд хүмүүжиж байна.

Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо, төрлөөр, оноор

Үзүүлэлт	Хичээлийн жил				
	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Нийт дүн	393	304	256	217	155
Харах эрхтэний	204	131	114	89	51
Сонсох эрхтэний	28	27	23	20	15
Хэл ярианы	58	48	44	39	32
Оюун ухааны	17	4	1	3	3
Бие эрхтэний	64	65	51	46	39
Хавсарсан	22	29	23	20	15

Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, өвчний төрлөөр, хувиар, 2018 он



Хөгжлийн бэрхшээлтэй хүний 3519 (85.8%) нь нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон, 596 (14.3%) нь хөдөлмөр эрхэлж байна.

Байнгын асаргаанд 1154 (28.1%) нь байгаа ба 513 (44.4%) нь эмэгтэйчүүд байна. Байнгын асаргаанд байгаа хөгжлийн бэрхшээлтэй 3 хүн тутмын 1 нь хүүхэд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны 528 хүүхдийн 384 (72.7%) нь байнгын асаргаанд байна.




ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 2018 онд 40017 өрх оршин сууж, өрхийн ам бүлийн дундаж тоо 3.9 болсон байна. Өрхийн тоо 1992 оноос 22632 өрхөөр буюу 1.3 дахин өссөн бол өмнөх оноос 531 (1.3%) өрхөөр буурсан байна. Чингэлтэй дүүрэгт Монгол Улсын нийт өрхийн 4.5 хувь, Нийслэл хотын нийт өрхийн 10.3 хувь нь байнга оршин сууж байна.

Хүснэгт 10. Монгол Улс, Нийслэл хотын өрхийн тоо, дүүргээр, оноор

Захиргаа	2014	2015	2016	2017	2018
Монгол Улсын нийт хүн ам	823 313	859 106	869 849	885 639	894 496
Нийслэлийн дүн	312 928	376 419	380 828	386 218	387 453
Чингэлтэй	39 785	41 540	40 589	40 548	40 017
Багануур	8 272	8 462	8 604	8 514	8 569
Багахангай	1 078	1 193	1 187	1 196	1 272
Баянгол	55 536	57 981	58 241	58 756	59 536
Баянзүрх	85 973	93 097	93 713	94 971	95 714
Налайх	9 755	10 051	10 349	10 547	10 606
Сонгиохайрхан	77 162	82 895	84 924	86 212	84 236
Сүхбаатар	35 963	37 920	38 021	38 272	38 563
Хан-Уул	39 189	43 280	45 200	47 202	48 940




Хүснэгт 11. Чингэлтэй дүүргийн өрхийн тоо, хороогоор, оноор


Захиргаа	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	39 785	41 540	40 589	40 548	40 017
1 -р хороо	926	939	935	936	931
2 -р хороо	899	888	975	978	924
3 -р хороо	1 564	1 612	1 610	1 632	1 703
4 -р хороо	1 431	1 460	1 549	1 304	1 394
5 -р хороо	1 267	1 261	1 308	1 286	1 245
6 -р хороо	1 862	2 065	2 002	2 005	2 035
7 -р хороо	3 424	3 369	3 361	3 376	3 282
8 -р хороо	1 260	1 243	1 206	1 178	1 165
9 -р хороо	1 856	1 830	1 753	1 740	1 747
10 -р хороо	1 808	1 912	1 808	1 839	1 817
11 -р хороо	1 522	1 553	1 463	1 421	1 409
12 -р хороо	3 757	3 773	3 727	3 727	3 662
13 -р хороо	1 989	2 040	2 006	2 004	1 952
14 -р хороо	1 966	2 083	2 026	1 944	1 981
15 -р хороо	1 997	2 160	2 201	2 387	2 223
16 -р хороо	2 907	3 441	2 988	2 992	3 189
17 -р хороо	3 812	4 066	3 868	3 872	3 715
18 -р хороо	2 544	2 703	2 560	2 701	2 497
19 -р хороо	2 994	3 142	3 243	3 226	3 146

Гэрлэлтээ бүртгүүлсэн өрхийн тоо 2018 онд 1146 болж өмнөх оноос 179 (18.5%) өрхөөр өссөн байна. Нийт өрхийн 1140 (99.4%) нь гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн хос байгаа бол 6 (0.6%) нь гэрлэлтээ дахин сэргээсэн хос байна. Гэрлэлтээ батлуулсан хүний 56.2 хувь нь 25-34 насны хос байна.

Зураг 9. Гэрлэсэн хос, насны ангилалаар, хувиар



Зураг 10. Гэрлэлтээ цуцалсан хос, хамт амьдарсан жилээр, хувиар




Шүүхийн шийдвэрээр 317 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 56 буюу 21.5 хувиар өссөн байна. Гэрлэлтээ цуцлуулсан хосын 48.4 хувь нь 30-39 насны хүн байна.

Өндөр настай ганц бие өрх 2018 оны жилийн эцсийн байдлаар 577 болж өмнөх оны мөн үеэс 168 (41.0%) өссөн байна. 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 1279 бүртгэгдэж өмнөх оноос 245 (23.7%) өрхөөр нэмэгдсэн байна. Мөн өрх толгойлсон хүн 2366 болж 45.2 хувиар буурсан байна.

Нийт өрхийн 79.4 хувь нь зөөврийн ундны үс хэрэглэдэг ба сайжруулсан ариун цэврийн байгууламжинд холбогдоогүй байна.

Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд Чингэлтэй дүүрийн нутаг дэвсгэр хамрагдаж байгаа тул 2018 оны “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-оор мал тоологдоогүй. Харин 6 хорооны 40 өрхөд 519 тэжээвэр амьтан тоологдсон байна.

2018 ОНЫ ТЭЖЭЭВЭР АМЬТАДЫН ТОО - 519




Дүүргийн нийт өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл 8267 өрх буюу 20.7 хувь нь нийтийн орон сууцанд, 465 өрх буюу 1.1 хувь нь бие даасан тохилог сууцанд, 19933 өрх буюу 49.8 хувь нь сууцны тусдаа байшинд, 11281 өрх буюу 28.2 хувь нь монгол гэрт амьдарч байгаа бол 71 өрх буюу 0.2 хувь нь өөрсдийн гэсэн орон гэргүй амьдарч байна.

Хүснэгт 12. Өрхийн тоо, сууцны төрлөөр, хороогоор, 2018 он

Захиргаа	Нийт өрхийн тоо	Нийтийн орон сууцанд амьдардаг	Тусдаа тохилог орон сууц амьдардаг	Байшинд амьдардаг	Монгол гэрт амьдардаг	Орон гэргүй /тэнэмэл/
1-р хороо	931	929	2	-	-	-
2-р хороо	924	924	-	-	-	-
3-р хороо	1 703	1 703	-	-	-	-
4-р хороо	1 394	1 393	-	-	-	1
5-р хороо	1 245	1 245	-	-	-	-
6-р хороо	2 035	2 035	-	-	-	-
Байшин хорооллын дүн	8 232	8 229	2	-	-	1
7-р хороо	3 282	-	135	1 690	1 453	4
8-р хороо	1 165	-	-	896	267	2
9-р хороо	1 747	-	18	1 258	471	-
10-р хороо	1 817	-	-	1 128	674	15
11-р хороо	1 409	-	6	1 050	349	4
12-р хороо	3 662	-	22	2 151	1 482	7
13-р хороо	1 952	-	7	1 327	613	5
14-р хороо	1 981	-	38	1 427	516	-
15-р хороо	2 223	38	18	1 672	487	8
16-р хороо	3 189	-	25	1 854	1 299	11
17-р хороо	3 715	-	28	2 093	1 591	3
18-р хороо	2 497	-	80	1 709	704	4
19-р хороо	3 146	-	86	1 678	1 375	7
Гэр хорооллын дүн	31 785	38	463	19 933	11 281	70

ӨРХ, ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2018 он



НИЙТ ӨРХ 40017